



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2018 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 127

Мандалговь

Хөрөнгө шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсгийн 77.2.3 дахь заалт , 77.3 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

Нэг: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн, нийт 139,994,721.00 (нэг зуун гучин есөн сая есөн зуун ерэн дөрвөн мянга долоон зуун хорин нэг) төгрөгийн балансын үнэтэй 3,6 км бкВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 160 кВА-ын дэд станц, 250 кВА-ын дэд станцыг тус тус “Багануур Зүүн Өмнөд Бүсийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ТӨХКомпанийн харьяа “Дундговь Цахилгаан түгээх сүлжээ салбар”-ын өмчид шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр: Аймгийн Цахилгаан түгээх сүлжээ салбарын дарга Г.Мягмарсүрэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай: Үүнд:

2.1. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.2. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 01 дүгээр сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР